

ХЯТАД, МОНГОЛ ХОЁР УЛС ХАМТРАН ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭЖ, ШОРООН ШУУРГААС СЭРГИЙЛЭХ НЬ

Ш.АМЖИЛТ, Э.НАРАН*

Шороон шуурга бол хүмүүсийн оршин амьдрах орчин ахуйг эвдэж, хүн төрөлхтөнд хүнд хэцүү хохирол учруулдаг байгалийн гамшиг юм. Тэр нь улс орны эдийн засаг нийгмийн хөгжилд ноцтой сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй үүссэн тухайн бүс нутгаасаа тэлээд урсгал дагуу дараачийн бүс нутгийн агаарын давхаргыг бохирдуулан нөлөөлдөг. Дэлхийн хэмжээний цөлжилт хэцүүдсэн нь шороон шуурга ширүүсч байгаагийн гол шалтгаан болсон юм. Одоо дэлхийн 100 гаруй орон адил бус хэмжээгээр цөлжилтийн аюулд нэрвэгдээд, хамарсан талбай нь 3 тэрбум га-гаас давав. Үүнд: умард Африк, төв Ази, Монгол, Хятад улс зэрэг нь цөлжилтийн хэцүү байдалд тулгарч байна. ХХ зууны сүүлийн жилүүдээс Хятад, Монгол улсад шороон шуурга шуурах нь олширч, хүн байгальд маш их аюул гамшиг, алдагдал хохирол учруулж байна.

Хятад улсын байгаль орчныг судлах эрдэмтдийн судалгаагаар, Хятад улсад нөлөөлж байгаа шороон шуургын нэг хэсэг нь хилийн цаанаас, нэг хэсэг нь хилийн дотор бүс нутгаас үүсэн босч байна гэж үзэж байна. Хилийн чанадад голдуу хойд хөрш Монгол Улсын зүүн өмнө хэсгийн говийн элсэрхэг

бүс нутаг ба төв Азийн Казахстаны зүүн хэсгийн элсжсэн бүс нутгууд болно. Хилийн дотоодод голдуу Өвөр Монголын дунд, зүүн хэсгийн Сөнидийн хотгор буюу Хулан шарга даага элсний дунд баруун бүс нутаг, Алашаа аймгийн Монгол Улстай хиллэж байгаа бүс нутаг, Синьзяний Такламаканы элсэн бүс гурван Төнхөт элсэн бүсийн нутаг орно.

Нэг. Шороон шуургын сөрөг нөлөө хийгээд шалтгаан

1. Хятад улс дахь шороон шуургын байдал

Хятад улс нь шороон шуургын нөлөө ихтэй улс орны нэг юм. Хятадын Хөхмөрөнөөс умарш ихэнхи бүс нутгийн 1.4 сая км-ийн доторхи 130 сая хүн ам нь шороон шуургын аюулд өртөж байна. Хятадад шороон шуурга ХХ зууны дунд үеэс эхлэн жилд 5-8 удаа шуурч байснаа 90-ээд он гэхэд 10-20 удаа болж, хамрах бүс нутгийн хүрээ нь тэлэгдэж, нөлөө хохирол учруулах хэмжээ нь улам өргөжив. Сүүлийн жилүүдэд хүчтэй шороон шуурга цөөн бус удаа болж гай гамшиг болсоор байна.

Хятад улс дахь 2000-2006 он хүртэлх элсэн шуургын байдал

Он	Шар тоос дэгдэх	Шороон шуурга	Хүчтэй шороон шуурга	Нийт шуурсан удаа	Тайлбар
2000	10	7	2	19	
2001	6	11	5	22	Хүчтэй шороон шуургатай жил
2002	9	3	5	17	
2003	8	2		10	Шороон шуурга нам жил
2004	12	5	1	18	
2005	6	6	1	13	
2006	7	5	5	17	Шороон шуурга чангарч байгаа жил

* Ш.Амжилт, Э.Наран. ӨМИС-ийн доктор, профессор

2007 он гэхэд шороон шуурга өнгөрсөн жилээс сулавтар бага байсан гэж хэлж болох хэдий ч 3-р сарын 30-ны өдрөөс 4-р сарын 1-ний өдрүүдэд Өвөр Монголын баруун дунд, Нинсягийн хойд, Шаньси мужийн хойд хэсгээр шороон шуурга босч, Баяннуур хот, Бугат хот, Шилийнгол аймгийн баруун хэсгээр ширүүсч, үзэгдэх орчин дөнгөж 1 км байж, заримдаа 100 м хүрэхгүй тэнгэр, газар нийлж байв. Монгол Улсын өмнөд хэсгээс эх авч Өвөр Монголын баруун хэсгээс чангарсан энэ удаагийн шороон шуурга Хятадын бүс нутгийн 680 мянган ам км, 6.3 сая хүн ам ба 32 сая га бэлчээр нутгийг хамарч, хаврын тариалалт, зулзаган модны нахиалалт болон зам харилцаанд ноцтой нөлөөлж хүмүүсийн үйлдвэрлэл амьдралд нэлээд хохирол учруулсан байна. Үүгээр зогсохгүй, энэ удаагийн хүчтэй шороон шуурга Хятадын хил хязгаарыг давж БНСУ, Японд хүрч, тэндхийн агаарын давхаргыг бохирдуулжээ. БНСУ-ын нийслэл Сөүл хотын үзэгдэх орчин зай 3 км хүрэхгүй болж, зарим газарт 1 км ч хүрэхгүй, хүмүүсийн ажил амьдралд ихээр нөлөөлж байв. 4-р сарын 2-ны өдөр шороон шуургын улмаас БНСУ-ын 1200 шахам бага дунд сургууль, хүүхдийн цэцэрлэгийн 1 өдрийн хичээл зогссон байна. Японы талын судалгаагаар, энэ удаагийн Японыг дайрсан шороон шуурга нь Японы хэд хэдэн хотыг шар өнгөөр будангуйруулснаар барахгүй шороон шуургын жижиг мөхлөгт нь кадми, хар тугалга зэрэг хүнд металлын нунтаг холилдож байв гэжээ.

Энд онцлон тэмдэглэхэд, БНСУ, Японыг дайрсан шороон шуурга нь Хятад улс санаатай хийсэн ажиллагаа бус гэдэг нь илэрхий. Шороон шуурга байгалийн үзэгдэл болохын хувьд, хүний эрхшээлд багтахгүй, улс гүрний хязгааргүй байгалийн гамшиг юм. Энэхүү шороон шуурга хил давж хөрш зэргэлдээ орнуудад нөлөөлж байгаа нь хөрш орнуудын хувь заяаг улам нягт холбож, хүчээ нэгтгэж шороон шуургатай тэмцэх нь тулгамдсан үүрэг болж байгааг харуулж байна.

2. Монгол Улс дахь шороон шуурга

Хятад улсын судалгаагаар, сүүлийн жилүүдэд шороон шуурга хамгийн хүчтэй шуурсан 2001 оны 22 удаагийн ихэнхи нь даруй 18 удаа нь Монгол Улсын өмнө хэсгийн бүс нутгаас үүсч хил давж орж ирээд ширүүссэн

байна. Монгол Улсын шороон шуурга нь Хятадын шороон шуургын эх үүсвэр болж байгаа тул сүүлийн жилүүдэд хоёр улсын шороон шуургын тоо хэмжээ ба нөлөөний хувьд нэлээд төстэй байна. 1960-аад онтой харьцуулахад, одоо Монголын тал хээр говийн бүсийн нутгаар шороон шуургатай өдрийн тоо 3—4 дахин нэмэгдсэн байна.

2007 оны байдлаар, Монголын нутагт 6-р сар хүртэл шороон шуурга үргэлжилж байлаа. “Үнэн” сонины мэдээлснээр, хүчтэй шороон шуурга шуурсны улмаас Монгол Улсын өмнөд хэсгийн 180 км төмөр зам элсэнд дарагдаж, говийн нутгийн төмөр замын хоёр талд 2—3 метрын өндөр элсэн дов бий болж, төмөр замын хөдөлгөөнд ихэд саад тотгор учруулсан байна. Монгол Улсад шороон шуурга дахин дахин тасралтгүй дайрч байгаа нь мөн л нутаг дэвсгэрийн цөлжилт өргөжиж байгаатай холбоотой юм. Монголын Байгаль Орчны Яамны судалгаагаас үзэхэд, Монголын нийт нутаг дэвсгэрийн 44.7 хувь буюу 650 мянган ам км талбай бүхий говь, цөлийн бүс нутагт цөлжих аюул илүү өртөж хэмжээ нь тэлсээр байна. Сүүлийн 10 жилд 380 ам км талбай бүхий нутаг бүрмөсөн цөлжив. Монгол Улсын нутаг дэвсгэрийн цөлжилт үргэлжлэн нэмэгдэх хандлагатай байна.

3. Монгол Улс ба Хятад улсад шороон шуурга ихсэж байгаагийн шалтгаан

Нэгд, дэлхий дахины дулааралт, уур амьсгалын өөрчлөлтөөс болж, сүүлийн 60 жилд Монгол орны агаарын жилийн дундаж температур 1.6 хэмээр нэмэгдэж, нийт нутгийн 1/4-ийг хамарсан ган хагасаргаа 4—5 жилд нэг удаа давтамжтай тохиолдож байна.

Хоёрт, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас сүүлийн 10 жилд Монгол Улсын гантай нутаг дэвсгэрийн талбай 3-4 хувь нэмэгдэв. 2003 оны байдлаар бүх улсын 5000 орчим гол мөрний 370 нь, 10 мянга орчим горхины 1000 илүү нь нэгэнт ширгэжээ.

Гуравд, хүмүүсийн зохисгүй үйл ажиллагаанаас болж Монгол Улсын ой модны нөөц жилээс жилд хомсдон, хорхой шавьж, түймэрт нэрвэгдэж байна.

Дөрөвт, сүүлийн жилүүдэд малын тоо толгой нэмэгдэж бэлчээрийн даацыг хэтрүүлэн ашиглахад хүргэж улмаар газар нутаг нь цөлжиж байна. Монгол Улсын 126.6 сая га

талбай бүхий бэлчээрийн 70 гаруй хувь нь ямар нэг хэмжээгээр талхигдалд орсон байна.

Хятадад шороон шуурга үүсч чангарч байгаагийн шалтгаан нь Монгол Улсад цөлжилт ихсэж, шороон шуурга үүсч байгаа бүх шалтгаантай адилавар байхаас гадна, хамгийн ноцтой нь Хятад улсын баруун хойд, умардын бүс нутгаар тариалангийн атар газар хагалбарлалт их хийснээс болж хөрс шороог ихээр муудуулсанд оршино.

Судалгаанаас үзэхэд, Монгол Улсад болсон шороон шуургын салхин хүч хэдийгээр маш ширүүн боловч тоос бутарч агаарыг бохирдуулах нь нам байж, Хятадын нутагт болсон шороон шуургын салхины хүч нь дахин чангарснаар барахгүй урсгал дагуу шороо тоосыг хуйлруулан дэгдээж маш их өргөн хэмжээний бохирдол үүсгэдэг байлаа. Үүний шалтгаан нь мөн Хятад улсад атар газрыг их хэмжээгээр хагалбарласантай холбоотой гэж үзэж байна.

Учир нь шороон шуургын гол болох хор нөлөө нь 100 микрометрээс бага диаметртэй бичил мөхлөг бодис юм. Эдгээр жижиг мөхлөг бодис нь голдуу тачирдсан бэлчээр нутаг, тариалангийн газар дахь тоос, хатаж ширгэсэн гол нуурын хэвлийгээс үүсдэг. Байгалийн элс нь шороон шуургыг их хэмжээгээр үүсгэх шууд шалтгаан биш юм. Иймээс шороон шуургаас урьдчилан сэргийлэх, цөлжилтийг зогсооход, газрын өнгөн давхаргын орчныг сайжруулах, хөрсний ургамлын бүрхцийг сэргээх, тариалангийн газрын шороо алдагдахыг хориглох, бэлчээрийн тачирдлыг сэргийлэх зэрэг экологийн бүтээн байгуулалт хийх нь зүй зохистой арга хэмжээ болох юм.

Хоёр. Цөлжилттэй тэмцэж шороон шуургаас урьдчилан сэргийлэхэд экологийн бүтээн байгуулалт хамгийн чухал.

1. Хятад улсын экологи орчныг хамгаалсан практик ажлын байдал

ӨМӨЗО-ны экологийн бүтээн байгуулалтын амжилтаас Хятад улсын экологи орчныг сайжруулж байгаа байдлыг олж харж болно. Өвөр Монгол нь бүх Хятадын умардын хамгийн чухал экологийн халхавч болсны хувьд, баруун бүс нутгийн хөгжлийг түргэтгэх стратегийг хэрэгжүүлэхдээ, Өвөр Монголын

экологийн бүтээн байгуулалтыг суурь бүтээн байгуулалт болгон хэрэгжүүлсэн явдал юм. Сүүлийн 6 жилд улсаас 20 тэрбум юаний хөрөнгө оруулж 17 сая га талбай бүхий цөлжиж элсэрхэгжсэн газар нутгийг сайжруулав. Иймээс, олон жил экологийн орчин муудаж хэцүүдэж байсан байдлыг өөрчилж **“Ерөнхийд нь хязгаарлаж, хэсэг газар сайжирсан”** түүхэн чанартай амжилт олж, угийн атаршсан тал, элсэрхэгжсэн говь нь өнөөдөр дахиад өвс модоор бүрхэгдэн, гол горхи урссан гоё үзэмжтэй болж хувирав.

Нэгд, бэлчээрийг хамгаалах.

Тал нутгийн экологи бол Өвөр Монголын экологийн гол цогц мөн. Бүх ӨЗО-д 88 сая га тал нутагтай, энэ нь бүх Өвөр Монголын нутаг дэвсгэрийн 74 хувийг эзэлнэ. Сүүлийн жилүүдэд уур амьсгал жилээс жилд гандуу болсны дээр, хүн амын өсөлт түргэсч, зүй зохисгүй ашигласнаас тал нутаг хүнд ноцтой элсэрхэгжин цөлжиж, мал аж ахуйн хөгжилтийг харшилснаар барахгүй, умард орны экологийн орчинд хүнд ноцтой нөлөөлөв.

Хүнд ноцтой байдлын өмнө, өвөр монголчууд цаг тухайд нь чиглэлээ өөрчилсөн юм. 1984 онд Өвөр Монгол нь “Гурван шат өмчилж, бригадаар суурь болгож” байсан хуучин тогтолцоог эвдэж, “Бэлчээрийг нийтээс өмчилж, эзэмшлийг даалгаж, мал сүргийг үнэ тогтоон өрхөд өмчлүүлж, өрхөөр малжуулах” агуулга бүхий “Мал бэлчээрийг хослуулан даалгах дүрэм”-ийг хэрэгжүүлэв. Үүний суурин дээр, 1989 онд “Нутаг бэлчээрийн өмчлөх эрх, ашиглах эрх хийгээд өрхөд даалгах хариуцлагын дүрэм”-ийг баталгаажуулан хэрэгжүүллээ. Одоогоор бүх ӨЗО-д нэгэнт нутаг бэлчээрийн өмчлөх эрхийг хэрэгжүүлсэн талбай 70 сая га, өрхөд даалгасан талбай 56 сая га болов. Өмчлөлийн эрх нь тодорхойгүй, нутаг бэлчээрийг хүн бүхэн дураараа хэрэглэх асуудлыг шийдвэрлэхийн төлөө, Өвөр Монголын Засгийн Газраас “Өрхөд даалгаж, өрхөөр тор татуулах” арга хэмжээ авснаар, одоо Өвөр Монголын торлосон бэлчээрийн талбай бүх даалгасан бэлчээрийн 41.1 хувийг эзлэв. Оторлохгүй малчин өрхийг урамшуулж, айл тосгон болж суурьшин амьдрах аргыг хэрэглэж байна. Өвөр Монголд малын тоо толгойг хязгаарлах, үүлдрийг сайжруулан, гаралтыг нэмэгдүүлэх төрийн бодлого хэрэгжүүлж

эхэлснээс Хөлөнбуйрын уулын 6 сая малыг цөөрүүлж 4 сая болгосон. Хэдий тийм байсан ч Өвөр Монголын тэжээвэр малын тоо нэмэгдсээр, 2006 оны бүртгэлээс үзвэл бүх ӨЗО-ны мал тэжээврийн тоо 110.5 саяд хүрч, өнгөрсөн оныхоосоо 4.1 хувь өссөн байна. Мал аж ахуйн гаралтын талаар, Өвөр Монголын үнээний сүү, хонины мах, ноос ноолуурын гаралт бүх Хятадад тэргүүлсээр байна. Энэ нь Өвөр Монголын тариалах газрын тэжээвэр малын үйлдвэрлэл бүх ӨЗО-ны мал тэжээврийн аж үйлдвэрийн гол хүчин болсны шалтгаан юм. Тариалах орны малын тоо толгойн харьцаа 5 жилийн өмнө 21 хувь байнаасаа 70 хувийг эзлэх болж, малжих орны малын тоо толгойн харьцаа 5 жилийн өмнө 79 хувь байснаасаа буураад 30 хувь орчим болжээ. Энэхүү түүхэн чанартай өөрчлөлт нь тал нутгийн экологийн сэргээлтэд чухал ач холбогдолтой болсоор байна.

Хоёрт, ногоон бүрхэвч бий болгох.

Газар зүйн байршлаасаа болж, Өвөр Монгол нь бүх Хятадын умардын хамгийн их экологийн халхавч болсон юм. Ой модны эх баялгийг хамгаалах ба бүтээн байгуулах нь Өвөр Монгол тэрчлэн бүх Хятадад эдийн засаг нийгмийг хөгжүүлэх, байгалийг хамгаалах чухал их ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд Өвөр Монголын газрын хөрс муудсанаас газар тариалан эрхлэх оронд тариалахыг зогсоож мод тарихыг урамшуулж байна. “Элсэрхэгжсэн газрыг хэн ойжуулбал хэн өмчлөх, хэн хөрөнгө оруулж мод таривал хэн ашгийг нь хүртэх” бодлого хэрэгжүүлснээр байгаль орчноо ногооруулснаар барахгүй өмчлөгчдийн орлого нь ихээр нэмэгдэв. Ой модны өмчлөлийн эрх хувирсан нь дээр үеийн зөвхөн засгийн газраас мөнгө гаргаж үй түмэн хүнийг цуглуулж албаар мод тарьж экологийн бүтээн байгуулалт хийж байснаасаа одоо ой модны өмчлөх эрхийг тодорхой болгон өрхөд даалгаж, тогтсон хугацаан дотор ногооруулалт хийх гэрээ тогтоон сайн дурын үр ашигтай ойжуулалтын бүтээн байгуулалт хийж байна. Үүний хамт, Өвөр Монголын экологийн бүтээн байгуулалтын ажлын шат бүрийн удирдлагын хэр бүтэмжийг нэг хяналттай болгож, хяналтын баримжаа, хэмжээг нарийвчлан чангаруулах алхам хийж дэс дараатай болгов. Энэ бүхний үр дүнд, одоогоор Өвөр Монголын ой модны

нийт талбай өргөжөөд 20.6 сая га болж, 3.3 сая га нэмэгджээ. Ургаа модны одоогийн байгаа нийт хэмжээ 1.3 тэрбум куб метрт хүрч 120 сая куб метрээр нэмэгджээ. Ой модны бүрхэц 17.5 хувь болж, “Х таван жилийн төлөвлөгөө”-ний хугацааны 17 хувийн нормоо урьдчилан давуулан биелүүлжээ.

Гуравд, тачиршил элсэрхэгжлийг хориглох.

Өвөр Монголд Бадайн жаран, Тэнгэр, Улаанбух, Хөвч, Баян-Өндөр зэрэг 5 их элсэн цөл болон 4 их элсэрхэг газар тархаж байдаг. Нөгөө талаар тачиршиж элсэрхэгжсэн газар бүх ӨЗО-ны 90 хувийн хошуу нутгаар тархаж байна. Энэ мэтийн байгаль орчин нь Өвөр Монголыг бүх Хятадын шороон шуурга шуурах “Голомт”-ын орон болгож, шороон шуурга нь умардын орнуудыг дайран, нийслэл Бээжинг дайрч, хэт хүчтэй шороон шуурга нь зүүн хойд орон хийгээд Тайвань, цаашлаад умард Америкийн хуурай эх газар хүртэл шар тоос дэгдээж байсан. ӨМӨЗО-ны Засгийн Газар тачиршил элсэрхэгжлийг хатуу хориглож шороон шуургыг дарахын тулд цөлжилт элсэрхэгжилтийн эхийг хязгаарлаж, элсэрхэг орны тариалан мал аж ахуйн үйлдвэрлэлийн арга хэлбэрийг өөрчлөх болон аж үйлдвэрийн бүтцийг тохируулах, элсэрхэг орны дэд бүтцийг сайжруулах зэрэг арга хэмжээ авсан юм. Үүнд: элсэрхэгжилтээс урьдчилан сэргийлж зогсоох мэргэжлийн үүдэлтэй системийн байгуулалтыг чангатгах, зангилаа асуудал болон мэргэжлийн чадварыг голлон судалж, энэ салбарын мэргэжилтэнг аймаг хошуунд олшруулах, улмаар элсэрхэгжил цөлжилтийн эсрэг тэдний хооронд тэмцээн уралдаан явуулсан юм.

Өвөр Монгол 2000 оноос эхлэн Бээжин, Тяньжиний шороон шуургын эхийг хорих байгаль орчныг хамгаалах инженерийн бүтээн байгуулалтыг хэрэгжүүлснээс хойш нэгэнт 2.2 сая га газрыг ойжуулан ногооруулав. Мони уулын ар хормойгоор урт нь 300 км, өргөн нь 50 км-ын экологийн халхавч хийгээд Хулан шарга даагын элсний өмнө хөвөөгөөр урт нь 400 км, өргөн нь 1-10 км орчмын “Эмжээр” маягийн хамгаалалтын бүсийн системийг бий болгов. Үүний хамт, малчин тариачин элсний аж ахуй, өвсний аж ахуй эрхэлж, элсэрхэг газрын бутлаг мод, үр жимс, өвсийг ашиглаж, шинэ зүйлийн хүнс ундаа, бордооны зүйл, хятад монгол

эмийн аж үйлдвэрийг хөгжүүлснээр малчин тариачны хүн бүрийн тэгшитгэсэн ой модны аж үйлдвэрийн орлого 250 юаньд хүрэв.

Өвөр Монголд, өнгөрсөн “Элс урагшилж хүн ухарсан” газруудад өнөөдөр хүний хүчээр “Ногоон бүрд” илэрч, элс манх ногоон тэрлэг өмсчихлөө. Жишээлбэл: Өвөр Монголын Ордосын Энгэр говь элс нь 1989 оноос өмнө хүн амьтангүй 20 мянган га талбайтай элсэн талбай нь үргэлж шороогоор шуурдаг гамшгийн орон байсан. Арван хэдэн жилийн турш улсын дотоод гадаадын хөрөнгө оруулалтаар тураг мод 3 сая ширхэг, бутлаг мод 30 мянган бут, сайн чанарын өвс 3500 га тарьж ургуулаад одоо ургамлын бүрхэц нь 40 гаруй хувь болов. Үүний зэрэгцээ бас үзэм жимс, цэцгийн хүрээлэн ба өвсөн үр, нялх модны бааз гээд олон зүйлийн эдийн засаг, аялал жуулчлалын үйлдэлтэй аж үйлдвэрийг хөгжүүлж байна. Өнөөдрийн Энгэр говь нь нэгэнт Өвөр Монголын хамгийн том элсэн нутгийн экологийн хамгаалалтын аялал жуулчлалын нэртэй газар болов. Энд онцлон тэмдэглэхэд, 1990 оноос эхлэн Японы элсийг ногооруулах ажлын нийгэмлэгийн дарга, 84 настай Тояма Татаакай профессор тэргүүтэй тусламжийн бүлгийнхэн Энгэр говьд ирж мод тарьж, ойжуулан арчилж байгаа нь Өвөр Монгол гэхгүй бүх Хятадын хүндэтгэл талархлыг хүртэж, 1998 онд тухайн үеийн Хятадын төрийн тэргүүн байсан Зян Зэминь дарга түүнийг хүлээн авч уулзаж байлаа. Тояма Татаакайн тэргүүлсэн Японы элсийг ногооруулах ажлын нийгэмлэгийн тусламжийг хүртсэн Энгэр говийн экологийн бүтээн байгуулалт дэлхийн олон орны анхаарлыг татаж, шороон шуургатай тэмцэх ба экологийн тэнцвэртэй орчныг бий болгох талаар хөрш зэргэлдээ оронтой хамтран ажилласны үлгэр жишээ болсон юм. 2004 онд Тояма Татаакай профессор 97 насандаа таалал төгсөв. Өвөр монголчууд түүний сайн үйлс сайн санааг үүрд дурсан үргэлжлүүлэх болно.

Өвөр Монголын экологийн бүтээн байгуулалтын амжилт бүх Хятадаа тэргүүн байрыг эзэлж байна. Бүх Хятадын 3 дахь удаагийн тачиршил цөлөрхөгжил хийгээд элсэрхэг газрыг шалган шинжилсэн дүнгээс үзвэл, Өвөр Монголын тачиршиж цөлөрхөгжсөн газар нь 933 сая га байж, 1999 оныхоосоо 24 сая га буурч, элсэрхэг газар 624 га байж 1999 оныхоос 7.3 га буурчээ.

Өвөр Монголын цөлжилттэй тэмцэж, байгаль экологийг сайжруулсан туршлагыг товчлон хэлбэл:

1) Байгууламж тогтолцооны өөрчлөн байгуулалт. Урьд өмнө бэлчээр нутаг улс нийтийн өмч байхад малчид ус өвсний сайн газарт оторлон маллаж, хайрлаж хамгаалахаар дутмаг, одоо бэлчээрийг өрхөд даалган эзэмшүүлснээр хүн бүхэн өөрийн бэлчээрээ хайрлан хамгаалах болов. 2) Урамшуулах бодлого. Тариалахаа зогсож өвс мод таригчдад тэтгэмжийн мөнгө олгосон нь малчин тариачны амьдралыг баталгаатай болгов. 3) Үйлдвэржилтийг хөгжүүлэх. Аж ахуйн нэгжүүд экологийн орчин сайжирсан газар элсний аж ахуй, өвсний аж ахуй, аялал жуулчлалын аж ахуй зэргийг хөгжүүлснээр малчин тариачны орлого улам нэмэгдэв. 4) Үйлдвэрлэлийн хэлбэрийг өөрчлөв. Малын тоо толгой ба бэлчээрийн даацын тэнцвэрийг батлахын төлөө, бэлчээрлүүлэхийг зогсоох, бэлчээрийг амруулах, орон тойрогт хуваан ээлжлэн бэлчээрлүүлэх, малыг хашаалж тэжээх зэрэг арга хэмжээ авсан нь бэлчээрийн ургамлын бүрхцийг сэргээв. 5) Экологийн нүүдэл. Малчдыг хүндрэлтэй амьдрах орчноос нь хот сууринд нүүлгэж амьдралын тэтгэмж, ажлын байр олгож байгаа нь бэлчээрийн ургамлын бүрхцийг сэргээснээр барахгүй малчдын амьдралыг баталгаатай болгов. Бас нэг хамгийн чухал зүйл нь ядуурлаас салж, баян чинээлэг болсон малчин тариачдын байгаль орчноо хамгаалах идэвхи улам нэмэгдэж сайн дураараа экологийн хамгаалагчид болж байна.

2. Монгол Улсын цөлжилттэй тэмцэх практик ажлын талаар

Монгол Улс нь цөлжилт болон шороон шуургатай нэн үр дүнтэй тэмцэхийн тулд 2005 оноос эхлэн “Ногоон бүсийн хөтөлбөр” хэрэгжүүлж их хэмжээгээр мод тарьж байна. 2006 оноос ган гачиг ихтэй говийн нутагт хүчээр бороо оруулж бэлчээрийн хөрсний чийг шимийг нөхөн сэргээв. Энэ жилээс Монгол Улсын Засгийн Газраас ард иргэддээ хүн бүр 3 ширхэг мод тарих үүрэг даалгавар өгч, улс нийтээрээ ногоожуулах хөдөлгөөнд идэвхтэй оролцохыг шаардаж байна.

Цөлжилттэй тэмцэх практик арга хэмжээ авах, тохирох технологи, арга зүй нэвтрүүлэх

асуудал тулгамдсан зорилт болж байна. Өнгөрсөн жилүүдэд цөлжилтөнд үлэмж нэрвэгдсэн Дорноговь аймгийн Замын-Үүд, Говь-Алтай аймгийн Хөх морьт сумдад элсний нүүдлээс хамгаалахад чиглэгдсэн төслүүдийг хэрэгжүүлэв. Тухайлбал Замын-Үүд сумын элсний нүүдлийн шалтгаан үр дагаврыг тогтоож, хөрс ургамалжилтын өнөөгийн байдалд үнэлгээ өгсний үндсэн дээр газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулж, Замын-Үүдийн цөлжилттэй тэмцэх 10 жилийн хөтөлбөр батлуулан нутгийн захиргааны байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна. Замын-Үүдийн төвд байгаль хамгаалах арга хэмжээний зардлаар жил бүр 7—10 га газарт мод тарьж, цөлжилттэй тэмцэхэд олон нийтийн оролцоог дээшлүүлэх зорилгоор сургалт, семинар зохион байгуулсан болно. Хөх морьт сумын төвийг элсний нүүлтээс хамгаалах зурвас байгуулах төсөл хэрэгжүүлж, бэлчээр усжуулах зорилгоор 6 худгийн насос суурилуулах ажил хийв.

Сүүлийн жилүүдэд 24.3 мянга орчим га ойжуулалт хийж, улсаас 870 сая төгрөг зарцууллаа. 2000 онд 9030 га, 2001 онд 8000 га газрыг шинээр ойжуулсан буюу нөхөн сэргээсэн байна. Монгол орны ойн 300 мянган га талбайд тархсан ойн хөнөөлт шавьжны судалгааны ажил хийгдэж, 8000 га талбайд хөнөөлт шавьжны устгалт хийгджээ. Монгол Улсын Усны үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эвдэрсэн худгийг сэргээх, шинэчлэх зардалд сүүлийн 2 жилд 522 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, нийт 337 худгийг ашиглалтанд оруулсан байна. Атаршиж эргэлтээс хасагдсан тариалангийн талбайд олон наст ургамал тарих, зурвас байгуулах ажил хийгдэж байна.

Гурав. Хятад, Монгол хоёр улс хөрш зэргэлдээ оронтой хүчээ хамтатган элсэн шуургыг сэргийлэх нь

Байгалийн асуудал, тухайлбал шороон шуурга бол дан ганц нэг улс гүрний асуудал биш, тэр нь улс гүрний хил хязгааргүй, даяарчилсан шинжтэй, бүсчилсэн шинжтэй байгалийн гамшиг юм. Тиймээс олон улс, нэн ялангуяа хөрш зэргэлдээ улс хүчээ хамтатган сэргийлэн тэмцэх нь хамгийн үр ашигтай арга зам мөн. Шинэ зуун эхэлснээс хойш, тухайлан 2001 онд Монгол, Хятад улсад ба Зүүн хойд Азийн улс орныг бүхэлд нь хамарсан хүчтэй

шороон шуурга нь нэгэнт хөрш зэргэлдээ орны анхаарлыг татаж, хамтран ажиллахын чухлыг яаравчлан таниулсан байна. Ингээд шороон шуургатай тэмцэх хөрш орон хийгээд олон улсын хамтын ажиллагаа эхэлсэн юм. 2002 онд Хятад, Япон, БНСУ, Монгол 4 улс нийлэн олон улсын холбогдох байгууллагатай хамтран шороон шуургаас урьдчилан сэргийлэх ажлын хэсэг зохион байгуулжээ. 2003 онд Хятад, Япон, Монгол, хоёр Солонгос зэрэг 5 улс гүрэн хамтран шороон шуургатай тэмцэх талаар дээд хэмжээний хурлыг зохион байгуулсан юм. 2004 онд Хятад, Япон, БНСУ 3 улсын Байгаль орчныг хамгаалах яамны сайд Япон улсад хуралдаж, шороон шуургаас урьдчилан сэргийлэх, шороон шуурга үүсэх шалтгаан, шороон шуургын эх үүсвэр ба тархалт жич шороон шуурга нь байгаль орчинд үзүүлсэн нөлөө зэрэг асуудлыг шинжлэн ярилцав. 2005 онд Япон улс нь Япон, Хятадын ногоожилтын санг байгуулж, Хятад улсын мод тарих ба ой модны аж ахуйг ихээр дэмжих болов. 2003 оноос өнөөг хүртэл БНСУ-ын Засгийн газар нь 1.3 сая ам.долларын хөрөнгө оруулж БНХАУ-ын Өвөр Монгол, Ляонин, Гирин зэрэг мужид шинжлэх ухааны 10 том стандартын шаардлага хангасан шороон шуургыг хянан шалгах өртөө байгуулав. Эдгээр өртөө нь тухайн орны салхины байдал, агаарын давхарга дахь элс шорооны мөхлөгийг тасралтгүй хянан шалгаж, шороон шуурга үүсэх, тархах, шилжих зэрэг байгаль орчны хувиралтын тоо баримтыг цаг тухайд нь бүртгэснээс шороон шуурга үүсэх жич түүний сөрөг нөлөө зэргийг нэлээд оновчтой урьдчилан мэдээлэх болжээ.

Монгол Улсын цөлжилттэй тэмцэх, шороон шуургаас урьдчилан сэргийлэх талаар олон улсын байгууллагатай идэвхитэй хамтран ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газраас Цөлжилттэй тэмцэх олон улсын байгууллага болон хандивлагч орнуудын тусламж, дэмжлэгийг авах, хамтын ажиллагааг хөгжүүлэх стратегийг баримталж байна. Цөлжилттэй тэмцэх Конвенцийг боловсруулахаас батлуулах шат хүртэл Монгол Улс идэвхтэй оролцож, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Хүрээлэн байгаа орчны хөтөлбөр, Цөлжилттэй тэмцэх Конвенцийн нарийн бичгийн дарга нарын газартай нягт хамтран ажиллаж ирлээ.

Монгол Улс хөрш зэргэлдээ орнууд болох ОХУ, БНХАУ болон нэг бүс нутагт орших Казахстан, Киргиз улстай Засгийн газрын төвшинд байгаль орчин, усны нөөц, хилийн усыг хамгаалах, ус цаг уур, орчны мониторингийн салбарт хамтран ажиллах талаар нийт 7 гэрээ хэлэлцээр, АНУ, Япон, ХБНГУ, Унгар зэрэг улсын Байгаль орчны яамтай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулж, хоёр талын хамтын ажиллагааг идэвхжүүлж байна. Олон улсын чанартай хурал, зөвлөлгөөн сургалтанд Монголын төлөөлөгчид мэдээлэл туршлага солилцох, илтгэл тавих зэргээр байнга оролцож байна.

2001 онд цөлжилттэй тэмцэхэд Байгаль орчны Конвенциудын уялдаа холбоог сайжруулах нь сэдэвт Үндэсний чуулга уулзалт, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх Конвенцийн Ази Африкийн чуулга уулзалт, мөн Конвенцийн Азийн талын уулзалтуудыг өөрийн оронд зохион байгууллаа. Мөн бүс нутгийн хамтын ажиллагаагаа хөгжүүлэх зорилгоор Азийн бүсийн Цөлжилттэй тэмцэх хөтөлбөрийн хүрээнд сэдэвчилсэн сүлжээнд хамрагдах боллоо.

Цөлжилттэй тэмцэх асуудалтай нягт холбоотой “Монгол Улсын тогтвортой хөгжил”, “Ядуурлыг бууруулах хөтөлбөр” НҮБ-ын санхүүгийн тусламжтайгаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.

Эцэст нь хэлэхэд, цөлжилттэй тэмцэх, шороон шуургаас урьдчилан сэргийлэх нь хүнд бэрхшээлтэй, төвөгтэй, урт хугацааны ажил үйлс болно. Түүний биелэлт нь тухайн улс орон хийгээд хөрш зэргэлдээ орон лугаа зохистой хамтрахыг шаардаад зогсохгүй, олон улсын байгууллагын өргөн дэмжлэг, хамтын ажиллагаа хэрэгтэй юм. Ялангуяа шороон шуургын эх үүсвэр болсон Монгол, Хятад хоёр улс хүчээ нэгтгэн хамтран ажиллах нь маш чухал байр суурийг эзэлнэ.

Хятад, Монгол хоёр улсын хамтын ажиллагаа хийгээд хөрш орнуудын тусламжтайгаар хоёр улсын шороон шуургаас урьдчилан сэргийлж цөлжилттэй тэмцэх, экологийн тэнцвэртэй орчныг хамгаалах талаар олон улсын хамтын ажиллагааны үлгэр жишээ болж чадна гэдэгт итгэж байна.